ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 05 өдөр Дугаар 08 Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлыг түр томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 161 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирлаар Баатарын Эрдэнэбулганыг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. Гүйцэтгэх захирал Б.Эрдэнэбулгантай холбогдох журмын дагуу онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ц.Шинэхүү/-д даалгасугай.

3. Гүйцэтгэх захирлын ажлыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Мөнхцэцэг/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ц.ШИНЭХҮҮ

ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ТӨХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
УЛААНБААТАР ХОТ
ТТМ1879 5745535